

## ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН СУРГАЛТ, БЭЛТГЭЛИЙН БОДЛОГО

### Нэг. Нийтлэг үндэслэл

Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай, Улсын нөөцийн тухай, Боловсролын ерөнхий хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого баримт бичгийн хоёрдугаар бүлэг “Иргэн бүрд чанартай боловсрол эзэмших эрх тэгш боломж бүрдүүлэн, тэгш хамруулж, бүх шатны боловсролын залгамж холбоог хангаж, сургалт, бэлтгэлийн чанарыг дээшлүүлсэн байна”, мөн шатны гурав дахь хэсэгт “Суралцагчийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагыг хангасан, бүтээлч, чадварлаг багш, хүний нөөцөөр хангана”, тав дахь хэсэгт “Нээлттэй боловсролын тогтолцоог хөгжүүлж, цахим сургалтын нэгдсэн платформ бий болгон хүн бүр орон зай, цаг хугацаанаас үл хамааран өөрийн хүссэн чиглэлээр насан туршдаа суралцах боломжийг бүрдүүлсэн байна”, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 2 дугаар бүлгийн 7 дугаар зүйлийн 7.1.6 дахь заалт, Онцгой байдлын байгууллагад алба хаах журам, хүний нөөцийн бодлогод үндэслэн алба хаагч нь хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, ажиллах нөхцөлийг сайжруулах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг дээшлүүлэх сургалт бэлтгэлийг зохион байгуулахад баримтлах үндсэн баримт бичиг байна.

### Хоёр. Сургалт, бэлтгэлийн бодлогын зорилго, зарчим

2.1. Алба хаагчдыг сургаж хөгжүүлэх, мэргэжлийн ур чадвар, мэдлэгийг сайжруулах, мэргэшүүлэх, сургалт, бэлтгэл, зохион байгуулах, өргөсөн тангарагтаа үнэнч хариуцлагатай байх хандлагыг төлөвшүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг дээшлүүлэх, байгууллагын зорилго, зорилтыг хэрэгжүүлэн ажиллахад үүсэх харилцааг зохицуулах, албан тушаалын чиг үүрэгтэй нь уялдуулан сургалтыг зохион байгуулахад энэхүү зорилго оршино.

#### 2.2. Бодлогын зарчим

2.2.1. Зорилго бодитой, зорилтууд хэрэгжихүйц байх;

2.2.2. Бодлогын хэрэгжилт нь Онцгой байдлын байгууллага, төв орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтэс, анги, салбаруудын дарга захирагч нарын дүрмээр хүлээсэн үүрэг, хариуцлага, алба хаагчдын идэвх санаачилга, талуудын оролцоонд тулгуурласан байх;

2.2.3. Бодлогод тусгасан үндэслэл, агуулга, зорилт, стратегийн зорилтууд, хэрэгжих үе шатууд, үнэлгээ, үр дүнг тооцох зарчим нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжуудтай нийцсэн байх;

2.2.4. Онцгой байдлын байгууллагын хөгжил, гамшгаас урьдчилан сэргийлэх, авран хамгаалах, хор уршгийг арилгах, бие бүрэлдэхүүний албаны хэрэгцээ, шаардлагад нийцсэн байх;

2.2.5. Сургалт, бэлтгэл нь хөнгөнөөс хүнд рүү чиглэсэн сургалтын аргад тулгуурласан байх;

2.2.6. Сургалт, бэлтгэлийн агуулга, арга хэлбэрийг сонгох боломж олгосон, уян хатан, харилцан уялдаатай, тасралтгүй хөгждөг байх;

2.2.7. Сургалт, бэлтгэлийн үйл ажиллагаа онолын мэдлэг, практик ур чадварын уялдааг хангасан тэгш хүртээмжтэй, нээлттэй хандлагатай байх зарчмыг баримтална.

### Гурав. Сургалт, бэлтгэлийн бодлогын зорилт

3.1. Алба хаагчдын сургалт, бэлтгэлийг эрхэлж буй албан тушаалын чиг үүрэгтэй нь уялдуулан ангилж зохион байгуулах;

3.2. Сургалт, бэлтгэлийн үйл ажиллагааг боловсронгуй болгох үндсэн чиглэл, хэрэгжүүлэх үе шат, арга замыг оновчтой сонгож, сургалтын бодлого, агуулга, хэлбэр, үндсэн зарчим, тогтолцоо, менежментийг зөв тодорхойлох;

3.3. Сургалтад орчин үеийн дэвшилтэд арга, технологийг нэвтрүүлэх;

3.4. Алба хаагчдыг албанд мэргэшүүлэх, гамшгийн нөхцөл байдлын үед оновчтой шийдвэр гаргах, багаар болон бие даан үүрэг гүйцэтгэх мэдлэг, дадлага, чадварыг олгох;

3.5. Сургалтын үр дүнг үнэлэхдээ цаг хугацаа, орон зайнаас үл хамааран тооцох тогтолцоонд шилжих;

3.6. Алба хаагчдын бие даан суралцах чадварыг дээшлүүлэх, сургалтын материаллаг баазыг бэхжүүлэхэд чиглэгдэнэ.

### **Дөрөв. Сургалт бэлтгэлийн бодлогын үндсэн чиглэл**

4.1. Онцгой байдлын байгууллагын хүний нөөцийн сургалт, хөгжлийн талаар дараах үндсэн чиглэлийг баримтална.

4.1.1. Сургалт бэлтгэлийн бодлого, хөтөлбөрийг (2025-2026 он, 2027-2028 он, 2029-2030 он) богино, дунд, урт хугацааны төлөвлөлтөөр анхан, дунд, ахисан түвшний сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх;

4.1.2. Онцгой байдлын байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх, мэргэжлийн дээд (бакалавр) боловсролтой, мэдлэг, ур чадвартай албан хаагчийг гадаад, дотоодын мэргэжлийн сургалтын байгууллагад захиалгаар сургаж бэлтгэх, сургалтын үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах;

4.1.3. Гадаад, дотоодын их, дээд сургуулийн бакалавр, магистр, адъюнктур, докторын сургалтад удирдах ажилтныг бэлтгэх, алба хаагчдыг суралцуулж, хөгжүүлэх;

4.1.4. Гадаад, дотоодын тэтгэлэгт хөтөлбөр болон мэргэшүүлэх сургалтад алба хаагчдыг суралцуулж, боловсролын зэргийг нь дээшлүүлж, хөгжүүлэх;

4.1.5. Байгууллагын болон алба хаагчийн сургалтын хэрэгцээ, шаардлагыг харгалзан мэдлэг, боловсролыг дээшлүүлэх давтан болон мэргэшүүлэх, ур чадварын сургалтыг тусгай хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу үр дүнтэй зохион байгуулах;

4.1.6. Бие бүрэлдэхүүний мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх бүтээлч санаачилгыг дэмжиж, тэдний өөрийгөө хөгжүүлэх боломж, нөхцөлийг бүрдүүлэх;

4.1.7. Сургалт бэлтгэлийн тогтолцоо, агуулга, арга зүй, хэлбэр, эрх зүйн зохицуулалтыг цаг үеийн шаардлагад нийцүүлэн тухай бүр шинэчилж, боловсронгуй болгох.

4.2. Сургалт бэлтгэлийн бодлого, хөтөлбөр төлөвлөлтийг боловсруулах үндсэн чиглэлийн хүрээнд.

4.2.1. Үндсэн баримт бичиг болох сургалт бэлтгэлийн хөтөлбөр, аргачлал, цаг сэдвийн төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр, шалгаж үнэлэх заавар, хяналтын хуудсыг хэрэгцээ шаардлага тулгарсан үед шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэх;

4.2.2. Бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлээр эзэмшсэн мэдлэг, боловсрол, мэргэжлийн ур чадвар, сэтгэл зүйн түвшин, бие бялдрын бэлтгэлжилтийн шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулж мөрдүүлэх;

4.2.3. Сургалт, бэлтгэлийг зохион байгуулах удирдамжийг тухайн жилийн байгууллагын зорилт, гамшгийн нөхцөл байдлын нэгдсэн мэдээнд үндэслэн шаардлагатай үед тухай бүрт шинэчлэн боловсруулах;

4.2.4. Бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийг шалгаж үнэлэх зааврын дагуу сургалт бэлтгэлийн үр дүнд жил бүр шинжилгээ хийж цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал, дүгнэлт боловсруулна.

4.3. Орчин үеийн дэвшилтэт технологи техник хэрэгсэл ашиглах үндсэн чиглэлийн хүрээнд.

4.3.1. Нисгэгчгүй нисдэг төхөөрөмж (дрон)-г ашиглаж гал түймэр унтраах, аврах, зайнаас тандах, мэдээлэл цуглуулах, хариу арга хэмжээ авах шаталсан сургалтыг зохион байгуулах;

4.3.2. Хиймэл оюун ухаан (AI) зэрэг дэвшилтэт технологи ашиглан гамшгийн нөхцөл байдлыг үнэлэх, хариу арга хэмжээ төлөвлөх сургалтыг зохион байгуулах;

4.3.3. Нисгэгчгүй нисдэг төхөөрөмж, хиймэл оюун ухаан (AI) зэрэг дэвшилтэт технологи ашиглах чиглэлээр гадаад улсад суралцах алба хаагчийг дэмжих;

4.4. Гамшгаас хамгаалах болон албаны сургалт бэлтгэлийн сургагч багш нарыг бэлтгэх, чадавхжуулах үндсэн чиглэлийн хүрээнд.

4.4.1. Онцгой байдлын байгууллагад 5-с дээш жил ажилласан, гамшгаас хамгаалах онолын болон практик дадлага туршлагатай алба хаагчдыг сонгон шалгаруулж, сургагч багшаар бэлтгэх, чадавхжуулах үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх;

4.4.2. Онцгой байдлын байгууллагын сургалт, бэлтгэлийн асуудал хариуцсан бүтцийн нэгж, албан тушаалтан, 5-с дээш жил ажилласан туршлагатай алба хаагчдыг тусгай сургалтад хамруулан багшлах эрхийн үнэмлэх олгох ажлыг зохион байгуулах;

4.4.3. Тусгай хөтөлбөр, төлөвлөгөө гарган олон улсын байгууллагаас хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн хүрээнд сургагч багш бэлтгэж, чадавхжуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

4.5. Сургалт бэлтгэлийн нэгдсэн төв, бүсийн болон зайн сургалтын танхим байгуулж, материаллаг баазыг бэхжүүлэх үндсэн чиглэлийн хүрээнд.

4.5.1. Бие бүрэлдэхүүний сурч хөгжих боломжийг хангах, сургалтын гарын авлага, техник хэрэгсэл, номын сан, зайны сургалтын танхим болон нэгдсэн сургалтын төвийг байгуулж, материаллаг баазыг үе шаттайгаар нэмэгдүүлэх;

4.5.2. Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын газар, хэлтсийг албаны сургалт, бэлтгэл зохион байгуулах орчин үеийн техник хэрэгслээр хангах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх;

4.5.3. Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын газар, хэлтэст сургалт бэлтгэлийн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, биеийн тамир-чийрэгжүүлэлтийн танхим, сэтгэл зүйн өрөө, сургалтын танхим, сургалтад шаардлагатай сургалтын орчныг бүрдүүлэх;

4.5.4. Төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтэс нь сургалтын нэгдсэн төв, цахим сургалтын танхим, номын санг байгуулж ашиглалтад оруулах;

4.5.5. Сургалт бэлтгэлийн үндсэн хичээлүүдийн сурах бичиг, гарын авлага, цахим сургалтын материал, мэргэжлийн түвшний сорилын эмхэтгэл зэрэг сургалтын хэрэглэгдэхүүнийг боловсруулах;

4.6. Сургалтын нэгдсэн сан бүрдүүлж ашиглах үндсэн чиглэлийн хүрээнд.

4.6.1. Байгууллагын хүний нөөцийн мэдээллийн сантай уялдсан сургалтын мэдээллийн нэгдсэн сан, цахим орчин бүрдүүлж алба хаагч бүр хүртээмжтэйгээр ашиглах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

4.6.2. Сургалтын мэдээллийн санг сургуулийн жилийн удирдамж, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилттэй уялдуулан хөгжүүлж, алба хаагч бүрт нээлттэй, хүртээмжтэйгээр ажиллуулах;

4.6.3. Сургалтын асуудал хариуцсан бүтцийн нэгж, албан тушаалтан нь заах арга зүйн чадвартай, мэдээллийн технологийн өндөр мэдлэг эзэмшиж, сургалтын талаар гадаад, дотоодын сургууль, байгууллагын дэвшилтэт арга технологийг судалж, нэвтрүүлэх арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх;

4.6.4. Сургалт бэлтгэлийн үр дүнг тооцохдоо мэдээллийн санг ашиглаж, цаашид сургалт бэлтгэлийг сайжруулах, боловсронгуй болгох санал дүгнэлтийг боловсруулах;

## **Тав. Сургалт, бэлтгэлийн ангилал**

5.1. Сургалт, бэлтгэл дараах ангилалаас бүрдэнэ. Үүнд;

5.1.1. Алба хаагчдад мэргэжлийн боловсрол олгох сургалт;

5.1.2. Алба хаагчдыг мэргэшүүлэх давтан сургалт;

5.1.3. Бие бүрэлдэхүүний бэлтгэлжилтийн сургалт;

5.1.4. Бүсчилсэн сургалт.

5.1.1. Алба хаагчдад мэргэжлийн боловсрол олгох сургалт нь;

5.1.1.а. “Боловсролын ерөнхий хууль”, “Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль” болон холбогдох бусад хууль тогтоомж, сургалтын стандарт, хөтөлбөрийн дагуу дотоодын их, дээд сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв болон бусад мэргэжлийн боловсрол олгох сургалтын байгууллагад суралцуулах;

5.1.1.б. Бакалаврын боловсролтой алба хаагчийг байгууллагын захиалгаар гадаад, дотоодын их, дээд сургууль, академид ахисан шатны боловсрол олгох;

5.1.1.в. Бакалаврын хөтөлбөрийн алба хаагч нарт зориулсан 3 болон 4 жилийн сургалтад Онцгой байдлын байгууллагад 3 ба түүнээс дээш жил үр бүтээлтэй ажиллаж байгаа, сахилгын шийтгэлгүй, цаашид албанд тогтвор суурьшилтай ажиллах алба хаагчийг харьяа байгууллагын саналын дагуу элсүүлэн суралцуулах;

5.1.1.г. Гадаад, дотоодын их, дээд сургууль, академи, магистрын сургалтад Онцгой байдлын албанд 5, түүнээс дээш жил ажилласан, цаашид дэвшин дээшлэх, удирдах албан тушаалтны нөөцөд бүртгэгдсэн алба хаагчийг ажлын үр дүн, харьяа байгууллагын саналын дагуу элсүүлэн суралцуулах;

5.1.2. Алба хаагчдыг мэргэшүүлэх болон давтан сургалт.

5.1.2.а. Онцгой байдлын байгууллагын бие бүрэлдэхүүний сургалт, бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөний дагуу гадаад, дотоодод мэргэшүүлэх болон давтан, ур чадварын сургалтад хамруулах сургалтыг зохион байгуулах ажлыг хариуцсан бүтцийн нэгж, албан тушаалтан, хариуцан зохион байгуулах;

5.1.2.б. Мэргэшүүлэх сургалт нь алба хаагчдыг эзэмшсэн мэргэжлийн чиглэлээр давтан сургах, туршлагын мэдлэг, ур чадвар, мэргэшлийн түвшин ахиулах;

5.1.2.в. Давтан сургалт нь алба хаагчийн нийтлэг эрх, үүргийг хэрэгжүүлэх мэргэжлийн чадамжийг дээшлүүлж, дадал, чадварыг нь хөгжүүлэхэд чиглэгдэх ба сургалтын агуулгын 60 ба түүнээс дээш хувь нь алба хаагчийг дадлагажуулж, чадваржуулах;

5.1.2.г. Онцгой байдлын албанд шинээр орсон болон туршилтын хугацаагаар ажиллаж байгаа хүнийг тусгай төлөвлөгөөний дагуу ажлын үр дүнг харгалзан 1 сараас доошгүй хугацааны чадваржуулах;

5.1.2.д. Алба хаагчдын эрүүл аюулгүй орчинд ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилгоор хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нийт ажилтны сургалтыг мэргэжлийн байгууллагатай хамтран хууль, дүрэм, журамд зааснаар зохион байгуулах;

5.1.2.е. Монгол хэл, бичиг, гадаад хэл болон дэвшилтэт технологи, хиймэл оюун ухаан ашиглалтын мэдлэг дээшлүүлэх;

5.1.2.ё. Алба хаагчдын давтан болон мэргэшүүлэх сургалтыг тодорхой орон зайнаас мэдээлэл, харилцааны хэрэгслүүдээр дамжуулан зайны сургалтын хэлбэрээр (утас, ном, сурах бичиг, гарын авлага, цахим харилцаа, видео г.м) зохион байгуулах;

5.1.2.ж. Нутаг дэвсгэрийн онцлог, ажил, үүргийн чиглэл, нөхцөл байдлаас хамааран бүсчилэн, хээрийн дадлага хосолсон хэлбэрийн сургалтыг зохион байгуулах;

### 5.1.3. Бие бүрэлдэхүүний бэлтгэлжилтийн сургалт

5.1.3.а. Гамшгаас хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, Цэргийн нийтлэг дүрэм, цэргийн бие бялдар, дасгал сургуулилтын нормативын сургалт;

5.1.3.б. Гамшиг, аюулт, үзэгдэл, ослын тухай ерөнхий ойлголт, авч хэрэгжүүлэх арга хэмжээ, үүсэж болох хүндрэл бэрхшээл, даван туулах, сэтгэл зүйн бэлтгэлжилт, аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох арга хэмжээний талаарх сургалт;

5.1.3.в. Онцгой байдлын байгууллагад ашиглагдаж буй гал түймэр унтраах, аврах техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн техникийн үзүүлэлт, ашиглалтыг эзэмшүүлэх сургалт.

### 5.1.4. Бүсчилсэн болон шинээр томилогдсон алба хаагчийн сургалт.

5.1.4.а. Бүсчилсэн сургалт нь бүс нутгийн гамшгийн эрсдэлийн үнэлгээнд тулгуурласан цаг агаар болон зонхилон тохиолддог гамшгийн төрөлд нийцүүлсэн сургалт.

5.1.4.б. Бүсчилсэн сургалтыг бүсийн төвийн захирагч удирдаж бүсийн аймгуудын Онцгой байдлын байгууллагын газар, хэлтэс, салбар нэгжийг нэгдсэн удирдлага зохион байгуулалттайгаар зохион байгуулна.

## **Зургаа. Зохион байгуулалт**

6.1. Сургалт, бэлтгэл хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж нь байгууллагын сургалт, бэлтгэлийг нэгдсэн удирдлагаар хангаж, Онцгой байдлын байгууллагын бие бүрэлдэхүүний сургалт, бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөг боловсруулж батлуулан, хэрэгжилтэд хяналт тавина.

6.2. Сургалт, бэлтгэл хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж бие бүрэлдэхүүнийг сургаж бэлтгэх, мэргэшүүлэх, давтан сургалтыг, өдөр тутмын сургалт, бүсчилсэн сургалт, ажлын байранд дадлагажуулах сургалтуудыг төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын холбогдох албан тушаалтан нар хариуцан зохион байгуулна.

6.3. Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллага, харьяа нэгжүүд сургалтын бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндсэн хэрэглэгч бөгөөд үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллана.

---о0о---

# ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН СУРГАЛТ, БЭЛТГЭЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

## Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай, Улсын нөөцийн тухай, Боловсролын ерөнхий хууль, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг тус тус үндэслэн Онцгой байдлын байгууллагын бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийг зохион байгуулах, алба хаагчдыг бэлтгэх, мэргэжил эзэмшүүлэх, мэргэшүүлэх, тэднийг хөгжүүлэх сургалтыг зохион байгуулах, сургалт бэлтгэлийн үр дүнг тооцох үндсэн баримт бичиг байна.

## Хоёр. Зорилго

2.1. Онцгой байдлын байгууллагын бие бүрэлдэхүүний сургалт, бэлтгэлийг зохион байгуулах, алба хаагчдыг хөгжүүлэх, мэргэжлийн ур чадвар, мэдлэгийг сайжруулах, мэргэшүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг дээшлүүлэх, дэвшилтэт ухаалаг төхөөрөмж ашиглаж сургалт, бэлтгэлийг хүртээмжтэй байдлаар зохион байгуулахад оршино.

## Гурав. Нэр томъёоны тодорхойлолт

3.1. **“Сургалт бэлтгэл”** гэж алба хаагч хуулиар хүлээсэн үндсэн үүргийг биелүүлэхэд шаардлагатай мэдлэг, дадлага, чадвар, бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэлийг эзэмшүүлэх, төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын үүрэг гүйцэтгэх бэлтгэл, бэлэн байдлын хангуулахад чиглэгдсэн зохион байгуулалттай, тодорхой зорилго, зорилт бүхий сургалт, бэлтгэлийн цогц үйл ажиллагааг;

3.2. **“Сургалт, бэлтгэлийн зохион байгуулалт”** гэж бие бүрэлдэхүүний сургалт, бэлтгэлийн талаар дэвшүүлсэн зорилт, тушаал, шийдвэрийг биелүүлж, болзошгүй гамшгийн цагийн байдлын үед үүрэг гүйцэтгэх бэлэн байдал, жигдрэлтийг хангахын тулд бүх шатны удирдлага, штаб, албан тушаалтнаас сургалтын үйл явцыг төлөвлөх, зохион байгуулах, үнэлэх, шаардагдах материал, санхүүгийн нөөцийг зохицуулах, хянах чиг үүргүүдийг хэрэгжүүлж буй үйл ажиллагааг;

3.3. **Давтан сургалт** гэж алба хаагчийн мэргэжлийн чиглэлээр давтан сургах, мэргэшлийн түвшин ахиулах, орон зай, цаг хугацаанаас үл хамааран мэргэжил, боловсрол, мэдлэг, чадвараа албан, албан бус сургалтаар болон амьдралын орчинд суралцах замаар тасралтгүй хөгжүүлэх, дээшлүүлэх үйл ажиллагааг;

3.4. **Сургалтын төлөвлөгөө** гэж тухайн төлөвлөгөө ямар агуулгыг хэрхэн судлах, ямар үр дүнд хүрэх, багшийн заах арга зүй, орчин хэрэглэгдэхүүнийг хэрхэн бүрдүүлэх зэргийг төлөвлөсөн баримт бичиг;

3.5. **Хичээлийн хөтөлбөр** гэж тухайн хичээлээр мэдлэг эзэмшүүлэх, чадвар, хандлага төлөвшүүлэх үйл ажиллагааны зохион байгуулалт, үнэлэх арга зүй, хэрэглэгдэхүүнийг тодорхойлсон баримт бичиг;

3.6. **Танхимын сургалт** гэж сургалтын график төлөвлөгөө, хуваарийн дагуу танхимын сургалтаар зохион байгуулах лекц, семинар, дадлагын болон бусад хэлбэрээр явуулах хичээл сургалтыг;

3.7. **Танхимын бус сургалт** гэж лекц, семинар болон бусад хэлбэрээр танхимд явуулах хичээл сургалт;

3.8. **Зайн сургалт** гэж цаг хугацаа орон зайг үл хамааран интернэт ашиглан олгодог сургалтын хэлбэр;

3.9. **Үнэлгээ** гэж мэдлэг чадварыг үнэлэхийн тулд нотлох баримт, материал, мэдээлэл цуглуулж, холбогдох үнэлэлт, дүгнэлт гаргах системтэй үйл явцыг;

3.10. **Сургалтын цаг** гэж цагийг хэмжих нэгж бөгөөд нэг сургалтын цаг нь 50 минут байна. Хоёр хичээлийн дунд завсарлагагүйгээр 90 минутад багтаан явуулах үйл явцыг;

3.11. **Мэргэжил** гэж боловсролын зэрэг эзэмшихэд шаардагдах мэдлэг, чадвар, хандлагын цогцыг;

3.12. **Мэргэшил** гэж тодорхой мэргэжлийн чиглэлээр нарийн мэргэшсэн, мэргэжлийн өндөр ур чадвар эзэмших үйл явцыг;

3.13. **Дадлага** гэж танхимын сургалтаар эзэмшсэн онолын мэдлэг, чадвараа практик үйл ажиллагаатай холбон бататган гүнзгийрүүлж, ур чадвар, дадал эзэмших үйл явцыг;

### **Дөрөв. Удирдлага, зохион байгуулалт**

4.1. Онцгой байдлын ерөнхий газрын Сургалт, бэлтгэл хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж сургалт, бэлтгэлийн бодлогын дагуу төлөвлөлт, удирдлага, зохицуулалтын үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ, төв орон нутгийн Онцгой байдлын байгууллага, салбар нэгжийн сургалт, бэлтгэлийн явц, үр дүнг хянаж, мэргэжлийн удирдлага зохион байгуулалтаар хангана.

4.2. Онцгой байдлын ерөнхий газрын Сургалт, бэлтгэл хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж нь холбогдох сургалтын байгууллагуудтай хамтран гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгаас хамгаалах чиглэлээр тулгамдсан асуудлын хүрээнд хийх шаардлагатай судалгаа, шинжилгээний ажлын сэдэв, чиглэлийг боловсруулан судалгааны ажлыг захиалгаар гүйцэтгүүлэх гэрээг магистр, адъюнктурт, докторт элссэн алба хаагчтай байгуулж, гэрээний үүргийн биелэлтийг хангана.

4.3. Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч нь энэхүү журам, сургуулийн жилийн удирдамж, төлөвлөгөөг үндэслэн бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийг зохион байгуулах тушаал, шийдвэр, сургалт, бэлтгэлийн төлөвлөгөө, хичээлийн хуваарь гарган хэрэгжилтийг зохион байгуулна.

4.4. Сургалт, бэлтгэлийн удирдамж, төлөвлөгөөг тухайн жил эхлэхээс 14 хоногийн өмнө Онцгой байдлын ерөнхий газрын Сургалт, бэлтгэл хариуцсан бүтцийн нэгж боловсруулж, Онцгой байдлын ерөнхий газрын даргаар батлуулан төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагад хүргүүлнэ.

4.5. Онцгой байдлын байгууллагын сургалт, бэлтгэлийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 05-ны өдрөөс 12 дугаар сарын 05-ны өдөр хүртэлх хугацаанд үргэлжилнэ. Сургалт, бэлтгэлийн жилийн 02 дугаар сарын хоёр дахь 7 хоногоос 05 дугаар сарын хоёр дахь 7 хоног хүртэл нийт 14 долоо хоногийн хугацаанд үргэлжлэх бөгөөд 1-р үе буюу эхний хагас гэх, 09 дүгээр сарын эхний 7 хоногоос 12 дугаар сарын эхний 7 хоног хүртэл нийт 14 долоо хоногийн хугацаанд үргэлжлэх бөгөөд 2-р үе буюу сүүлийн хагас байна.

4.6. Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын салбар нэгжийн нийт бие бүрэлдэхүүн, офицер, ахлагч, гэрээт ажилтан, тусгай мэргэжлийн ажилтан алба хаагчид 7 хоногт 1 удаа хичээллэнэ. Нэг өдрийн хичээлийн үргэлжлэх хугацаа сургалтын 2-4 цаг, сургалтын нэг цагийг 50 минутаар тооцох бөгөөд дундаа засварлагагүй 90 минутаар үргэлжилнэ.

4.7. Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч нар нь сургалт бэлтгэлийн агуулга, арга зүй, технологийг боловсронгуй болгох, сургалтын орчин, материаллаг баазыг бэхжүүлэх, алба хаагчийн өөрийгөө хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх ажлыг хариуцаж, сургуулийн жилийн удирдамжийн биелэлт, сургалт бэлтгэлийг зохион байгуулсан тайлан, мэдээ, дүнг сургуулийн жилийн үе бүрийн төгсгөлд болон жилийн эцэст Сургалт, бэлтгэл хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжид хүргүүлнэ.

4.8. Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын орлогч дарга, бие бүрэлдэхүүний сургалт хариуцсан албан тушаалтан нь сургалт бэлтгэлийг төлөвлөх, зохион байгуулах, удирдан явуулах, хянах чиг үүргийг хариуцан хэрэгжүүлж, өөрийн салбар, нэгжүүдийн албаны болон гамшгийн үед үүрэг гүйцэтгэх бэлтгэл, бэлэн байдлын үр дүнг хариуцна.

4.9. Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын бие бүрэлдэхүүний сургалт хариуцсан албан тушаалтан нь алба хаагчдыг мэргэшүүлэх, бие бүрэлдэхүүний сургалтын арга зүйг боловсронгуй болгох, сургалт бэлтгэлд шинэлэг арга, технологи, туршлагыг нэвтрүүлэх, хичээлүүдийн хөтөлбөр боловсруулах, хичээлийн конспект-төлөвлөгөөг хянаж, удирдлагад танилцуулан баталгаажуулж тайлагнана.

4.10. Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын офицерууд нь батлагдсан төлөвлөгөөний дагуу хариуцсан бие бүрэлдэхүүнийхээ сургалт, бэлтгэлийг удирдан зохион байгуулж тайлагнана.

4.11. Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагууд бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийг хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй, цэргийн алба, соёл хүмүүжлийн ажилтай нягт уялдуулан зохион байгуулна.

4.12. Томилгоот ээлжийн буюу 24 цагаар үүрэг гүйцэтгэдэг анги, салбар, бүлгийн дарга, захирагч нь анги, салбарын цагийн хуваарийн дагуу сургалт, бэлтгэл, хичээлийг батлагдсан хөтөлбөр төлөвлөгөөний дагуу зохион байгуулна.

4.13. Энэхүү журамд заагдаагүй сургалт бэлтгэлтэй холбогдсон бусад асуудлуудыг Онцгой байдлын ерөнхий газрын дарга, төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч нарын тушаал, шийдвэрээр зохицуулна.

### **Тав. Сургалт, бэлтгэлийн төрөл**

5.1. Онцгой байдлын байгууллагын сургалт, бэлтгэл нь дараах төрлүүдтэй байна.

Үүнд:

5.1.1. Нийт бие бүрэлдэхүүний;

5.1.2. Томилгоот ээлжийн;

5.1.3. Эрэн хайх аврах анги, аврах нохойн;

5.1.4. Улсын нөөцийн салбарын;

5.1.5. Агаараас эрэн хайх аврах;

5.1.6. Тусгай мэргэжлийн (эмч, сувилагч, оёдолчин, эсгүүрчин, тамирчин, эрдэм шинжилгээний ажилтан гэх мэт);

5.1.7. Гэрээт ажилтны гэсэн төрөлтэй байна.

5.2. Онцгой байдлын байгууллагын сургалт, бэлтгэлийн төрлүүдээр зохион байгуулах сургалтыг цаг сэдвийн төлөвлөгөөнд нарийвчлан тусгаж зохион байгуулна.

5.3. Журмын 5.1.6, 5.1.7-т заагдсан тусгай мэргэжлийн болон гэрээт ажилтны сургалтын хөтөлбөрийг тухайн нэгжийн үйл ажиллагааны онцлогт тохируулан боловсруулж сургалтыг зохион байгуулж болно.

### **Зургаа. Сургалт бэлтгэлийн үр дүнг тооцох**

6.1. Сургалт, бэлтгэлийн үр дүнг “Бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийг шалгаж үнэлэх заавар, аргачлалын”-ын дагуу тооцно.

6.2. Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын бие бүрэлдэхүүний сургалт, бэлтгэлд хийсэн хяналт шалгалтын үр дүн, сургуулийн жилд дэвшүүлсэн зорилго, зорилтын хэрэгжилтэд Хяналт шалгалтын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж хяналт, шинжилгээ хийнэ.

6.3. Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагчийн шийдвэрээр томилогдсон ажлын хэсэг нь сургалт, бэлтгэлийн хяналтын шалгалтыг батлагдсан шалгаж үнэлэх заавар, аргачлалын дагуу сургалт, бэлтгэлийн 2-р үе дууссанаас хойш 14 хоногийн дотор зохион байгуулж дүнг илтгэх хуудсаар баталгаажуулан Сургалт, бэлтгэл хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжид албан бичгээр ирүүлнэ.

6.4. Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллага, нэгжийн сургалтын ерөнхий дүн нь тухайн алба хаагчийн болон төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллага, нэгжийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг дүгнэх үндсэн үзүүлэлтийн нэг шалгуур нь байна.



### **Долоо. Шагнал, урамшуулал, хүлээх хариуцлага**

7.1. Сургалт, бэлтгэлийн зорилго, зорилт, удирдамж, төлөвлөгөөний биелэлтийг хангалттай биелүүлсэн алба хаагчийг шагнаж урамшуулах тухай төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч саналыг үндэслэн нотлох баримтад тулгуурлан шагнаж урамшуулах асуудлыг Онцгой байдлын ерөнхий газар шийдвэрлэнэ.

7.2. Сургалт, бэлтгэлийн зорилго, зорилт, удирдамж, төлөвлөгөөний биелэлтийг хангалтгүй биелүүлсэн удирдлага, албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага тооцно.

---oOo---

# **БИЕ БҮРЭЛДЭХҮҮНИЙ СУРГАЛТ, БЭЛТГЭЛИЙГ ШАЛГАЖ ҮНЭЛЭХ ЗААВАР, АРГАЧЛАЛ**

## **Нэг. Нийтлэг үндэслэл**

Бие бүрэлдэхүүний сургалт, бэлтгэлд хамрагдсан байдлыг харгалзан мэдлэг, чадварын үнэлгээ нь сургалтын болон хичээлийн хөтөлбөрөөр тодорхойлсон цогц чадамжийн хүрсэн түвшинг тогтооход чиглэх бөгөөд шинжлэх ухааны үндэслэлтэй, бодитой, шударга, ил тод байх зарчмыг удирдлага болгоно.

### **Хоёр. Шалгалтын арга, хэлбэр, хамрах хүрээ**

2.1. Онцгой байдлын байгууллагын бие бүрэлдэхүүний сургалт, бэлтгэлийн бодлого хөтөлбөр, журмыг үндэслэн бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлд хийх шалгалтын ажлыг зохион байгуулна.

2.2. Хүн нэг бүрийн мэдлэгийг аман болон бичгээр (тест), гүйцэтгэх болон даалгавар-ур чадварыг онол болон дасгалаар гэсэн шалгалтын хэлбэрийн аль нэгээр, эсвэл тэдгээрийн хосолсон хэлбэрээр шалгаж үнэлнэ.

2.3. Аман болон бичгээр (тест) авах шалгалтыг урьдчилан бэлдсэн асуултад хариулт авах арга хэлбэрээр авч үнэлнэ. Аслагдсан сум орон нутагт үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдаас амаар болон бичгээр (тест) авах шалгалтыг цахим хэлбэрээр авч болно.

2.4. Амаар авах шалгалт нь өгөгдсөн асуултын хүрээнд онолын болон хэрэглээний тайлбар өгөх, тодорхой тохиолдлыг шийдвэрлэх, шинжилгээ, дүгнэлт, харьцуулалт хийж тайлбарлан ярих хэлбэртэй байна.

2.5. Бичгээр авах шалгалт нь өгөгдсөн асуултын хүрээнд хариулт өгөх чөлөөт бичлэгийн болон тестийн, түүнчлэн бодлого бодох, төсөл боловсруулах, зураглал үйлдэх зэрэг хэлбэртэй байна.

2.6. Шалгалтыг тестээр авах бол нэг сорилд хариулах хугацаа 1 минут (нөхөх, харгалзуулах, асуудал шийдвэрлэх сорилд хариулах хугацааг өөрөөр тогтоож болно), чөлөөт бичлэгийн аргаар авах бол 1 асуултад хариулах хугацаа 15 минутаас багагүй байхаар тус тус тогтооно. Бодлого бодох, төсөл боловсруулах, зураглал үйлдэх хугацааг шалгалтын удирдамжаар тухайлан тогтооно.

2.7. Тодорхой үйлдэл, үйл ажиллагааг биечлэн гүйцэтгүүлэх шалгалт нь дасгал, нормативыг биечлэн гүйцэтгэх, өгөгдсөн нөхцөл байдалд тохируулан мэргэжлийн үйл ажиллагааг удирдах, зохион байгуулах, тодорхой үйлдлийг бие даан болон хамтран гүйцэтгэх, түүний учир холбогдлыг тайлбарлан ярих хэлбэртэй байна.

2.8. Жагсаалын бэлтгэлийн биеэр гүйцэтгүүлэх шалгалтаар хүн нэг бүрийг үнэлж дүгнэхдээ ганцаарчилсан болон салаа, бүлгээр ажиллуулан шалгаж болно.

2.9. Онцгой байдлын ерөнхий газрын даргын нэрэмжит болон сургуулийн жилийн төгсгөлийн шалгалтад бие бүрэлдэхүүний 90-ээс доошгүй хувийг, хяналтын буюу удирдамжийн шалгалтад 60-аас доошгүй хувийг хамруулна.

2.10. Сургалт, бэлтгэлийн хяналтын шалгалтыг тухайн анги, байгууллагын бие бүрэлдэхүүний жагсаалын үзлэгээр эхэлж, нэгдсэн дүнгийн хурлаар дуусгана.

### **Гурав. Бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийг шалгаж үнэлэх чиглэл, хугацаа**

3.1. Сургалт, бэлтгэлийг дараах чиглэлийн дагуу шалгаж үнэлнэ. Үүнд:

3.1.1. Бие бүрэлдэхүүний мэдлэг, дадлага- ур чадвар, сэтгэл зүй, бие бялдрын бэлтгэлийг шалгаж үнэлэх;

3.1.2. Албаны болон гамшгийн нөхцөл байдлын үед үүрэг гүйцэтгэх бэлтгэл, бэлэн байдал, жигдрэлтийг шалгаж үнэлэх;

3.1.3. Сургалт бэлтгэлийн хөтөлбөр, төлөвлөгөө, сургуулийн жилд дэвшүүлсэн зорилго, зорилтын хэрэгжилт, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг шалгаж үнэлэх.

3.1.4. Сургалт, бэлтгэлийн хяналтын шалгалтыг сургуулийн жилд 1 удаа газар, хэлтэс, анги байгууллагын дарга, захирагчийн тушаалаар томилогдсон ажлын хэсэг энэхүү зааврыг удирдлага болгон зохион байгуулна.

### **Дөрөв. Бие бүрэлдэхүүний сургалт, бэлтгэлийг шалгаж, үнэлэх**

4.1. Онцгой байдлын байгууллагын бие бүрэлдэхүүний сургалт, бэлтгэлийг дараах төрлийн хүрээнд шалгаж үнэлнэ. Үүнд:

- 4.1.1. Нийт бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэл,
- 4.1.2. Ахлагч бүрэлдэхүүний сургалт, бэлтгэл
- 4.1.3. Эрэн хайх, аврах анги, аврах нохойн
- 4.1.4. Улсын нөөцийн салбарын
- 4.1.5. Агаараас эрэн хайх, аврах
- 4.1.6. Тусгай мэргэжлийн (эмч, сувилагч, оёдолчин, эсгүүрчин, тамирчин, эрдэм шинжилгээний ажилтан гэх мэт)
- 4.1.7. Гэрээт ажилтны сургалт, бэлтгэл

4.2. Сургалт, бэлтгэлийн төрөл тус бүрт үнэлэгдсэн онооны нийлбэр нь тухай салбар, нэгжийн ерөнхий үнэлгээ байна.

Үнэлгээний оноо	Харгалзах үсгэн үнэлгээ	Үнэлгээ	Үнэлгээний шалгуур, болзол
90-100	A	Маш сайн	Цогц чадамжийг бүрэн эзэмшсэнийг илэрхийлнэ. Бие даан мэргэжлийн үйл ажиллагааг чадварлагаар явуулах боломжтой.
80-89,99	B	Сайн	Цогц чадамжийг хангалттай эзэмшсэнийг илэрхийлнэ. Бие даан мэргэжлийн үйл ажиллагааг хэвийн явуулах боломжтой.
70-79,99	C	Хангалттай	Цогц чадамжийг дундаж түвшинд эзэмшсэнийг илэрхийлнэ. Бусдын дэмжлэгтэйгээр мэргэжлийн үйл ажиллагааг явуулах боломжтой.
60-69,99	D	Дутагдалтай	Цогц чадамжийг дунджаас доош түвшинд эзэмшсэнийг илэрхийлнэ. Нэмэлт богино хугацааны сургалтад хамрагдсаны дараа мэргэжлийн үйл ажиллагааг явуулах боломжтой.
0-59,99	F	Хангалтгүй	Цогц чадамж хангалтгүй болохыг илэрхийлнэ. 1 жилээс доошгүй хугацааны сургалтад хамрагдсаны дараа дахин шалгалт өгөх боломжтой.
Шалгалт тасалсан, журам зөрчсөн	FE		Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шалгалт өгөөгүй, шалгалт өгөхөөс татгалзсан, эсхүл шалгалтын явцад тогтоосон журмыг зөрчиж, хуулах хууран мэхлэх арга хэрэглэхийг завдсан болохыг илэрхийлнэ.
Шалгалт хойшлуулсан	E		Хүндэтгэн үзэх шалтгаанаар тухайн өдрийн шалгалтыг хойшлуулсан болохыг илэрхийлнэ.

4.3. Алба хаагч бүрийг бие бүрэлдэхүүний сургалт, бэлтгэл зохион байгуулах журам, хөтөлбөрт заасан хичээлүүдээс 10-аас багагүй хичээл сонгон тухайн сургуулийн жилийн сургалт бэлтгэлээр эзэмшвэл зохих агуулгын хүрээнд шалгаж, тоон болон үсгэн үнэлгээгээр дүгнэнэ. Хичээл тус бүрийн тоон дүнгийн нийлбэрийг тухайн шалгалтад хамрагдсан хичээлийн тоонд харьцуулан алба хаагч бүрийн ерөнхий үнэлгээг гаргана.

4.4. Хичээлийг үнэлэхдээ шалгагдсан алба хаагч тус бүрийн тоон дүнгийн нийлбэрийг тухайн шалгалтад хамрагдсан алба хаагчийн тоонд харьцуулан хичээлийн ерөнхий үнэлгээг гаргана.

4.5. Тухайн алба хаагчийн сурлагын ерөнхий дүнг гаргахдаа шалгагдсан хичээл тус бүр авсан тоон үнэлгээнүүдийг нэмж, хичээлийн тоонд хувааж гаргах бөгөөд сурлагын амжилт, чанарыг хувилж гаргана.

#### **Тав. Хяналтын шалгалтын баталгаажуулалт**

5.1. Хяналтын шалгалтын илтгэх хуудсанд дараах үндсэн мэдээллийг тусгана.  
Үүнд:

5.1.1. Шалгалтын зохион байгуулалт, хэрэгжүүлсэн арга хэмжээ, онцлог, шалгалт авсан хичээлүүдийн дүн, алба хаагч бүр болон төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын сургалтын амжилт, түүнд хийсэн үнэлэлт, дүгнэлт,

5.1.2. Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын албаны болон гамшгийн цагийн байдлын үед үүрэг гүйцэтгэх бэлтгэл, жигдрэлтийн түвшин,

5.1.3. Сургуулийн жилийн зорилго, зорилт, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн,

5.1.4. Сургалтын орчин нөхцөл, материаллаг баазыг бэхжүүлэх талаар хийсэн ажил, сургалт бэлтгэлээр олсон амжилт, нэвтрүүлсэн тэргүүн туршлага, менежмент, гаргасан алдаа, дутагдал, түүний шалтгаан,

5.1.5. Сургалт бэлтгэлээр дэвшүүлсэн зорилго, зорилтыг хэрэгжүүлсэн байдлыг сургуулийн жилийн I үеийн болон төгсгөлийн үр дүнтэй харьцуулж, дутагдлыг арилгах арга зам, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ

5.1.6. Бусад

---oOo---